



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс:7034-2580  
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.02.19

№

70

танай

ны №

т

**БАЯН-АГТ СУМЫН ЭМТ-ИЙН  
ДАРГА Б.ХУЛАН ТАНАА**

**Аудитын тайлан хүргүүлэх тухай**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар нийт 4,072.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,072.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3 зөвлөмж өгөгдсөнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**

**Ж.ЭНХЦООДОЛ**



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Булган аймгийн Баян-Агт сумын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: Аудитын код: БУА-2024/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь ТАГ-ын дарга,  
тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч : Ж.Энхцоодол  
Утас:70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn  
Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг  
Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjmaitsetseg@gmail.com  
Ахлах Аудитор: Б.Нарантуяа  
Утас:99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС            Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС            Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ            Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082. Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.08.19

№

60

танай

ны №

г

Баян-Агт сумын Эрүүл Мэндийн  
Төвийн дарга Б.Хулан танаа

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-агт сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-агт сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Баян-агт сумын ЭМТөв нь эхний үлдэгдэл 64,160.5 мянган төгрөг, 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,066,197.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 956,229.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	263,794,950.80	416,216,483.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	64,160,531.35	5,818,705.70
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	64,160,531.35	5,818,705.70
3121	Төгрөг	64,160,531.35	5,818,705.70
31211	Төрийн сангийн харилцах	64,160,531.35	5,818,705.70
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	20,083,603.57	243,487,099.71
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,951,098.00	243,354,594.14
335	Бусад авлага	132,505.57	132,505.57
3352	Хувь хүмүүсээс авах авлага	132,505.57	132,505.57
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	179,550,815.88	166,910,678.35
351	Түүхий эд материал	125,656,764.39	104,710,101.16
3511	Тусгай зориулалттай материал	18,824,640.97	25,547,992.97
3513	Эм боох материал	106,832,123.42	79,162,108.19
354	Хангамжийн материал	52,909,051.49	61,215,577.19
3541	Бичиг хэргийн материал	3,474,700.00	1,728,300.00
3542	Аж ахуйн материал	38,275,931.00	33,503,605.50
3543	Сэлбэг хэрэгсэл	3,858,667.00	3,546,667.00
3544	Түлш, шатах тослох материал		4,246,402.40
3545	Барилгын засварын материал		1,880,800.00
3546	Хүнсний материал	7,299,753.49	9,754,802.29
3547	Бусад хангамжийн материал		6,555,000.00
356	Мал амьтад	985,000.00	985,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	758,719,544.63	940,338,779.05
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	758,719,544.63	940,338,779.05
392	Биет хөрөнгө	744,435,294.42	926,167,028.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	559,946,445.92	559,946,445.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	-66,437,018.37	-86,369,114.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42,900,000.00	242,062,903.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,233,839.28	-13,638,006.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	291,273,140.76	352,157,780.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	-116,439,934.49	-159,534,389.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,727,250.29	58,727,250.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,300,750.41	-27,185,841.73
393	Биет бус хөрөнгө	14,284,250.21	14,171,750.21
39301	Програм хангамж	1,600,000.00	1,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,643,749.79	-1,756,249.79
39303	Бусад биет бус хөрөнгө	14,328,000.00	14,328,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,022,514,495.43	1,356,555,262.81

IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	183,833.51	15,146,479.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	183,833.51	15,146,479.22
413	Өглөг	183,833.51	15,146,479.22
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	183,833.51	1,012,362.72
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,549,416.50
4136	Бусад өглөг		7,584,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг		7,584,700.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,022,330,661.92	1,341,408,783.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,022,330,661.92	1,341,408,783.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	307,097,069.44	307,097,069.44
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	627,890,901.58	946,969,023.25
5121	Өмнөх үеийн үр дүн	627,890,901.58	627,890,901.58
5122	Тайлант үеийн үр дүн		319,078,121.67
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	87,342,690.90	87,342,690.90
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,022,514,495.43	1,356,555,262.81

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	862,941,122.35	1,564,874,144.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,141,476.07	1,069,683,976.60
120	Нийтлэг татварын бус орлого	61,141,476.07	404,400,855.15
120001	Хувьцааны ногдол ашиг		7,972,356.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	775,000.00	157,394,220.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	775,000.00	51,441,220.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		38,226,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	40,712,669.40	231,947,543.47
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,653,806.67	23,031,447.68
122	Тусламжийн орлого		665,283,121.45
122001	Хандив тусламж /дотоод/		665,283,121.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	801,799,646.28	495,190,167.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,862,100.00	75,662,100.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,862,100.00	75,662,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	740,937,546.28	419,528,067.64
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	740,937,546.28	419,528,067.64
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	879,510,328.35	1,245,796,022.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	879,510,328.35	1,245,297,942.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	874,769,648.88	1,239,097,941.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,876,803.55	730,595,637.46
210101	Үндсэн цалин	325,396,646.00	527,274,845.46
210102	Нэмэгдэл	136,124,848.04	154,170,405.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,147,000.00	13,675,000.00
210104	Урамшуулал	30,208,309.51	35,475,387.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,291,980.19	90,811,582.95
210201	Тэтгэврийн даатгал	42,671,763.73	61,629,915.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,019,713.40	7,785,775.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,908,733.01	4,345,505.46
210204	Ажилгүйдлийн даатгал	925,155.31	3,536,389.26
210205	Эрүүл мэндийн даатгал	9,766,614.74	13,513,996.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,149,920.53	57,307,566.32
210301	Гэрэл, цахилгаан	4,087,912.06	4,196,203.58
210302	Түлш, халаалт	51,062,008.47	52,913,362.74
210303	Цэвэр, бохир ус		198,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,127,673.00	85,550,149.60
210401	Бичиг хэрэг	4,411,675.00	4,885,400.00
210402	Тээвэр, шатахуун	39,695,998.00	32,642,797.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,360,300.00	2,085,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	124,700.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	535,000.00	38,533,352.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		7,003,700.00
210408	Бараа материал акталсны зардал		399,100.00
2105	Нормативт зардал	129,243,907.14	156,423,504.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116,401,986.84	141,225,793.31
210502	Хоол, хүнс	12,841,920.30	13,214,711.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,983,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,979,000.00	31,292,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		18,679,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		75,000.00
210604	Урсгал засвар	6,979,000.00	12,537,540.00
2107	Томилолт, зочны зардал	6,682,000.00	5,710,000.00

210701	Гадаад албан томилолт		120,000.00
210702	Дотоод албан томилолт	6,682,000.00	5,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,486,698.00	1,252,432.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,623,626.00	1,053,102.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	612,372.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	967,800.00	
210807	Газрын төлбөр	40,500.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	48,200.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,931,666.47	80,154,629.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,060,619.31	2,224,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,871,047.16	77,930,229.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,740,679.47	6,200,000.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,740,679.47	6,200,000.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,740,679.47	6,200,000.68
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		498,079.98
	Дотоод эх үүсвэрээр		498,079.98
222001	Тоног төхөөрөмж		498,079.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,569,206.00	319,078,121.67
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16,569,206.00	319,078,121.67

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	782,623,548.28	1,092,291,914.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	775,000.00	822,677,341.45
120	Нийтлэг татварын бус орлого	775,000.00	157,394,220.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	775,000.00	157,394,220.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	775,000.00	51,441,220.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		38,226,400.00
122	Тусламжийн орлого		665,283,121.45

122001	Хандив тусламж /дотоод/		665,283,121.45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	781,848,548.28	269,614,573.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,862,100.00	75,662,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,862,100.00	75,662,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	720,986,448.28	193,952,473.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	720,986,448.28	193,952,473.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	812,836,371.53	1,152,805,838.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	812,836,371.53	1,152,805,838.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	807,767,432.69	1,146,605,837.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,216,301.04	748,464,540.86
210101	Үндсэн цалин	321,172,293.00	497,377,199.00
210102	Нэмэгдэл	134,942,452.04	191,582,631.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,147,000.00	16,307,289.67
210104	Урамшуулал	34,954,556.00	43,197,421.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,768,649.19	81,736,531.74
210201	Тэтгэврийн даатгал	43,159,930.76	51,978,428.49
210202	Тэтгэмжийн даатгал	4,996,071.12	7,703,904.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,015,665.19	3,833,215.89
210204	Ажилгүйдлийн даатгал	921,786.96	4,706,985.26
210205	Эрүүл мэндийн даатгал	9,675,195.16	13,513,997.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,821,661.16	57,307,566.32
210301	Гэрэл, цахилгаан	3,759,652.69	4,196,203.58
210302	Түлш, халаалт	51,062,008.47	52,913,362.74
210303	Цэвэр, бохир ус		198,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,020,700.00	46,051,420.00
210401	Бичиг хэрэг	3,703,000.00	2,714,500.00
210402	Тээвэр, шатахуун	39,692,700.00	36,781,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,300.00	1,849,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	124,700.00	752,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,000,000.00	3,953,320.00
2105	Нормативт зардал	97,031,233.30	97,663,163.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,052,883.30	80,219,563.00
210502	Хоол, хүнс	11,978,350.00	12,748,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	4,695,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,097,290.00	98,523,144.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		76,036,100.00

210604	Урсгал засвар	12,097,290.00	22,487,044.00
2107	Томилолт, зочны зардал	6,682,000.00	5,710,000.00
210702	Дотоод албан томилолт	6,682,000.00	5,710,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,149,498.00	6,817,172.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,884,626.00	5,442,102.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,200.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	612,372.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	105,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	33,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	967,800.00	180,000.00
210807	Газрын төлбөр	40,500.00	143,280.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,450,000.00	220,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,980,100.00	4,332,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,980,100.00	4,332,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,068,938.84	6,200,000.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	328,259.37	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	328,259.37	
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,740,679.47	6,200,000.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,740,679.47	6,200,000.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-30,212,823.25	-60,513,923.65
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,528,285.00	
	Дотоод эх үүсвэрээр	20,528,285.00	
223001	Бусад хөрөнгө	20,528,285.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-20,528,285.00	
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-50,741,108.25	-60,513,923.65
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		64,160,531.35
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,818,705.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн				
8	.....				
9	.....				
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,097,069.44	87,342,690.90	627,890,901.58	1,022,330,661.92
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			319,078,121.67	319,078,121.67
18	.....				
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,097,069.44	87,342,690.90	946,969,023.25	1,341,408,783.59

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,152,805,838.60	1,152,805,838.60	1,094,382,338.60	1,973.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,152,805,838.60	1,152,805,838.60	1,094,382,338.60	1,973.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,146,605,837.92	1,146,605,837.92	1,088,182,337.92	1,962.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	748,464,540.86	748,464,540.86	-697,185,040.86	1,459.58
210101	Үндсэн цалин	497,377,199.00	497,377,199.00	-461,585,499.00	1,389.64
210102	Нэмэгдэл	191,582,631.00	191,582,631.00	-176,534,831.00	1,273.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,307,289.67	16,307,289.67	-15,867,289.67	3,706.20
210104	Урамшуулал	43,197,421.19	43,197,421.19	-43,197,421.19	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,736,531.74	81,736,531.74	-74,592,531.74	1,144.13
210201	Тэтгэврийн даатгал	51,978,428.49	51,978,428.49	-47,120,528.49	1,069.98
210202	Тэтгэмжийн даатгал	7,703,904.88	7,703,904.88	-7,132,404.88	1,348.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,833,215.89	3,833,215.89	-3,547,415.89	1,341.22
210204	Ажилгүйдлийн даатгал	4,706,985.26	4,706,985.26	-4,421,185.26	1,646.95
210205	Эрүүл мэндийн даатгал	13,513,997.22	13,513,997.22	-12,370,997.22	1,182.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,307,566.32	57,307,566.32	-57,307,566.32	
210301	Гэрэл, цахилгаан	4,196,203.58	4,196,203.58	-4,196,203.58	
210302	Түлш, халаалт	52,913,362.74	52,913,362.74	-52,913,362.74	
210303	Цэвэр, бохир ус	198,000.00	198,000.00	-198,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	46,051,420.00	46,051,420.00	-46,051,420.00	
210401	Бичиг хэрэг	2,714,500.00	2,714,500.00	-2,714,500.00	
210402	Тээвэр, шатахуун	36,781,600.00	36,781,600.00	-36,781,600.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,849,500.00	1,849,500.00	-1,849,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	752,500.00	752,500.00	-752,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,953,320.00	3,953,320.00	-3,953,320.00	

1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,092,291,914.95	1,092,291,914.95	1,033,868,414.95	1,869.61
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,662,100.00	75,662,100.00	-75,662,100.00	
132001	Орон нутгийн төсвөөс	75,662,100.00	75,662,100.00	-75,662,100.00	
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	193,952,473.50	193,952,473.50	-135,528,973.50	331.98
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	193,952,473.50	193,952,473.50	-135,528,973.50	331.98
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	157,394,220.00	157,394,220.00	-157,394,220.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,441,220.00	51,441,220.00	-51,441,220.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,226,400.00	38,226,400.00	-38,226,400.00	
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	665,283,121.45	665,283,121.45	-665,283,121.45	
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	665,283,121.45	665,283,121.45	-665,283,121.45	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64,160,531.35	64,160,531.35	-64,160,531.35	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,818,705.70	5,818,705.70	-5,818,705.70	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага нь "Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлага зохицуулалтаар хангах. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар үр дүнг сайжруулах" зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Баян-Агт сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, дотоод журам, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймгийн Баян-Агт сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар журмаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,076.3 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	64,160.50	5,818.70	-58,341.80
Авлага	20083.6	243,487.10	223,403.50
Бараа материал	179,550.80	166,910.70	-12,640.10
Үндсэн хөрөнгө	758,719.50	940,338.80	181,619.30
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,022,514.40</b>	<b>1,356,555.30</b>	<b>334,040.90</b>
Өр төлбөр	183.8	15146.5	14,962.70
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	307,097.10	307,097.10	0.00
Хуримтлагдсан үр дүн	1,022,514.50	1,356,555.30	334,040.80
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,022,514.40</b>	<b>1,356,555.30</b>	<b>334,040.90</b>

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 12,640.1 мянган төгрөгөөр буурсан, үндсэн хөрөнгө 181,619.2 мянган төгрөгөөр өссөн, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 419,528.0 орон нутгийн төсвийг 75,662.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 730,595.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайланд онд гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 419,528.0 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 75,662.1 мянган төгрөг, оны эхний үлдэгдэл 782,623.5 мянган төгрөг нийт 1,092,291.9 мянган төгрөгийн санхүүжүүлт авч, 96.27 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 42,103.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган аймгийн Баян-Агт сумын ЭМТ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Майкрофт аудит" ХХК-ний аудитор Г.Майцэцэг, аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар тус тус хэрэгжүүлэв.

Булган аймгийн Баян-Агт сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг 171 мэдээ тайлан тайлагнах байсан хугацаа хоцорсон 5 мэдээлэл байна.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, стометрийн заалтыг дахин нягтлаж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягтлаж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Зөвлөмж

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримтлаж ажиллаагүй байна. Зөвлөмж

Мөнгөн гүйлгээний орлогыг бүртгэхдээ 107,241,405.65 төгрөгөөр данс бүртгэлийг буруу бүртгэсэн, Бараа материалын тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангаас 19161086.01 зөрүүтэй байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Зөвлөмж

Эд хариуцагч нь агуулахын бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан " Маягт заавар батлах тухай"-г стандартын дагуу хөтлөөгүй байна. Зөвлөмж

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 37 нэр төрлийн нийт 3,660,886.40 төгрөгний эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Төлбөрийн акт тогтоох

Бараа материалын хүнсний тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 31.7кг 412,100 төгрөгийн үхрийн мах дутсан байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Төлбөрийн акт тогтоох

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, няравын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Зөвлөмж

Анхны өртөгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНБББОУС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ " хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	187,5	1	187,5	100
Албан шаардлага					
Зөвлөмж	2	0	2	0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>187,5</b>	<b>3</b>	<b>187,5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, сиситемийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын бус зардал гаргахгүй байх, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийж хэрэгжүүлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших, бараа материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт бичиг хүчин төгөлдөр болно", "Анхан шатны бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж тус тус заасан байдаг. Тиймээс компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байх

Санхүүгийн тайлан болон Анхан шатны баримтыг үдэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, НББ тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу архивлан баримтжуулж, дотоод хяналтыг сайжруулахыг санхүүгийн албанд зөвлөж байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 4,072.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,072.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 37 нэр төрлийн нийт 3,660.8 мянган төгрөгний эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Акт тогтоох

Бараа материалын хүнсний тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 31.7кг 412.1 мянган төгрөгийн үхрийн мах дутсан байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Акт тогтоох

### **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага бичигдээгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, стOMETрийн заалтыг дахин нягтлаж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягтлаж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс





БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 06 дугаар сарын 14

Дугаар 02/А - 25452520

Булган сум

ЗУА - 2025/073/НА - СТА - ТУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Баян-Агт сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмийн үлдэгдлийг түүврийн аргаар тоолоход 3,660,886 (Гурван сая зургаан зуун жаран мянга найман зуун наян зургаан) төгрөгөөр эм дутагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акти зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Актаар тогтоосон 3,660,886 (Гурван сая зургаан зуун жаран мянга найман зуун наян зургаан) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Агт сумын ЭМТ-ийн дарга (Б.Хулан), нягтлан бодогч (Н.Бямбасүрэн) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  
"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ  
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.МАЙЦЭЦЭГ

0211  
11072025



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны дугаар сарын 19

Дугаар 01/33 - 25452520  
ЭЧА - 2025/073/НА - СГА - ТМЗ

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Баян-Агт сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын хүнсний тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулгахад 412,100.0 (Дөрвөн зуун арван хоёр мянга нэг зуун) төгрөгөөр бараа дутагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зорчсон байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Актаар тогтоосон 412,100.0 (Дөрвөн зуун арван хоёр мянга нэг зуун ) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Агт сумын ЭМТ-ийн дарга (Б.Хулан), нягтлан бодогч (Н.Бямбасүрэн) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ  
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.МАЙЦЭЦЭГ